



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/159

Есөнбулаг сум

Хурдан морины уралдаан зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн морин спорт, уяачдын холбооны саналыг харгалзан "АЛТАЙН ХҮЛЭГ" морин спорт уяачдын холбооны 30 жилийн ойн нэрэмжит "Засагт ханы хурд-2026" аймгийн бүсийн хурдан морины уралдааныг 05 дугаар сарын 04-ны өдөр Азарга, Их нас, Соёолон, Жороо морь, Сонгомол дээд насны ангиллаар Алтай хотод, аймгийн хаврын бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд Хөхморьт сумд, аймгийн зуны урд, хойд бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 07 дугаар сарын 18-22 ны өдрүүдэд Дарив, Эрдэнэ сумуудад, аймгийн зуны төвийн бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 07 дугаар сарын 31-ээс 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд Шарга сумд тус тус зохион байгуулахыг дэмжсүгэй.

2. Хурдан морины унаач хүүхдүүдэд стандартын шаардлага хангасан хувцас хэрэгсэл өмсгөх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, олон нийтийн хэв журмыг сахиулж, хяналт тавьж тайлагнан ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Б.Алтайбаатар), Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун), Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), аймгийн Морин спорт, уяачдын холбоо (Ц.Саруултөгс) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ